



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

VI ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2021 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь Их танхимд 62.5 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ

1. "Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын төслийн танилцуулга;

*Батлан хамгаалахын сайд,  
Улсын онцгой комиссын орлогч дарга  
Г.Сайханбаяр,*

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшинг тогтоох тухай;

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,*

3. "Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Коронавируст халдвар (КОВИД-19) илэрсэн объектыг хамгаалалтад авах түр журам", "Голомтот бүс нутгаас агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэхэд баримтлах халдвараас сэргийлэх түр заавар"-ын төслийн танилцуулга;

*Шуурхай штабын орлогч дарга,  
Хурандаа Б.Мандахгэрэл нарын мэдээллийг сонсов.*

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Нэг: Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт:

1.1. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Хоёр: Улсын онцгой комиссын гишүүд,

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт:

2.1. Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын шар түвшинд шилжүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах;

2.2. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын түвшин тогтоох, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам", "Гэрийн болон тусгаарлан ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Коронавируст халдвар (КОВИД-19) илэрсэн объектыг хамгаалалтад авах түр журам"-уудыг мөрдүүлж, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах;

Гурв: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн А.Ариунзаяа,

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан,

Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа,

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Д.Нарантуяа нарт:

3.1. "Нэг хаалга - Нэг шинжилгээ" тандалт илрүүлэлтийн шинжилгээ өгсөн иргэд, өрхийн мэдээллийг "Хүн ам, өрхийн мэдээллийн систем"-д шинэчлэн бүртгэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

Дөрөв. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд.

Тагнуулын ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, хурандаа П.Одонбаатар.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ нарт.

4.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах, вакцины төлөвлөлт, нийлүүлэлт, тээвэрлэлт, хадгалалт хийх бүртгэлийн системийн бэлэн байдлыг хангах, вакцинд хамрагдсан хүн амд төрийн үйлчилгээний нэгдсэн систем /emongolia/-ээр дамжуулан цахим лавлагаа /код/ олгох ажлыг зохион байгуулах;

4.2. Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд ашиглаж буй программ хангамж, үүсэж буй иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн сан, систем, сүлжээний аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж, хувь хүний мэдээлэл алдагдах, кибер халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлаар талаар холбогдох зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Тав. Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд.

Улсын онцгой комиссын орлогч дарга,  
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян.

Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд  
Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт.

5.1. Улсын онцгой комиссын даргын 2021 оны 12 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн "Нэг хаалга - Нэг шинжилгээ" арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Улсын онцгой комисст танилцуулах;

Зургаа. Боловсрол, шинжлэх ухааны сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн П.Энх-Амгаланд.

6.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед бүх шатны боловсролын байгууллагын 2020-2021 оны хичээлийн жилийн хоёрдугаар хагас жилийн танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрөөс үе шаттай эхлүүлэх саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх;

Долоо Гадаад харилцааны сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Батцэцэг,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,  
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэ,

Аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт.

7.1. Улсын хэмжээнд "CLIX GPS" системийн бүртгэлийг хийж, ашиглах, хяналт тавих, хэрэгжилтийн тайланг гаргах ажилтанг томилон ажиллуулах;

7.2. Гэртээ тусгаарлагдаж байгаа иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн болон нисэх буудал дээр гадаад улс орноос ирсэн иргэдийн гар утсанд "CLIX GPS" системийг суулгаж шалгах, туршилтын ажлыг шуурхай зохион байгуулах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
ДЭД ХУРАНДАА

Т.МӨНХДОРЖ



